



Хууль бус агнуур, худалдаа ховор ан амьтдын жагсаалтыг уртасгасаар...

Сүүлийн 10 гаруйхан жилийн дотор ховор болон элбэг ан амьтдын тоо толгой багассаар сүйрлийн ирмэгт ирээд байна. Тухайлбал: 1980 иад онд 40 000 орчим аргал хонь, 140 000 орчим халиун буга, тоологдож байсан бол 2001, 2004 оны тооллогоор 13000 орчим аргал хонь, 10 000 орчим халиун буга тоологдож, 2000 оны тооллогоор 5000 орчим байсан монгол бөхөн 2005 онд 1500 орчим монгол бөхөнтэй гэсэн дүн гарсан. Ховор, нэн ховор амьтдын тоо толгой арав гаруйхан жилд 70-90 хувь огцом буурч байна. Ховор амьтнаар ч зогсохгүй элбэг гэж үзэгддэг агнуурын ач холбогдолтой амьтад тарвага, цагаан зээр зэрэг амьтдын тоо толгой ч цөөрсөөр байна. Монгол улсын Засгийн газар 2005 онд ховор амьтны жагсаалтад тул, баавгай 2-ыг оруулсан явдал нь нэг талаас эдгээр зүйл амьтдыг хамгаалах статус өндөр болж байгаа боловч нөгөө талаас ан амьтад ховордсоор сүйрлийн ирмэгт байгааг илэрхийлж байгаа юм.

Ан амьтдыг сүйрлийн ирмэгт хүргэж байгаа нэг том хүчин зүйл бол ангийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зохисгүй буюу хууль бус худалдаа юм. Үүнийг ихэнх хүмүүс хулгайн ан ихэсээд ан амьтан цөөрч байна гэж ойлгодог нь өрөөсгөл талтай.

Монгол оронд хууль бус агнуурыг бууруулах нөхцөл боломж бол ангийн гаралтай эд зүйл, түүхий эдийн худалдааг хязгаарлах явдал юм.

Ан амьтны түүхий эд зүйлийн хууль бус худалдаа дэлхийд хар тамхины дараагаар ордог бол монголд алтны дараагаар орох зах зээл бий болж магадгүй байна.

Иймд Дэлхийн байгаль хамгаалах сангийн монгол дахь хөтөлбөрийн газар ан амьтны түүхий эд зүйлийн худалдааг хязгаарлах зорилгоор эрхзүйн орчинг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах ажлуудыг дэмжин ажиллаж байна.

Нийгэм социализмын тогтолцоотой байсан 1990-иэд оноос өмнө ядууралтай холбоотойгоор хууль бус агнуур гардаг байсан. Энэ цаг хугацаанд хувийн өмч байгаагүй учраас ангийн гаралтай түүхий эдийг хүнс болон ахуйн хэрэглээнд хэрэглэх зорилгоор хууль бусаар агнадаг байсан. Гэвч буу, сумны олдоц хязгаарлагдмал, хуулийн хэрэгжилт сайн, ангийн гаралтай түүхий эдийн зах зээл хаалттай байсан учраас хууль бус агнуур их хэмжээтэй байгаагүй. Төлөвлөгөөт эдийн засгийн үед анчин гэж мэргэшсэн хүмүүсийг хэлдэг нэр томъёо байлаа. Тэрхүү мэргэшсэн анчин гэдэг маань нэг талаас тодорхой эрх үүрэгтэй байгаль хамгаалагч байсан. Өөрөөр хэлбэл ангийн нөөцийг зохистой ашиглах тогтолцоо хэрэгжиж байсан юм. Тухайлбал жил бүр агнах амьтны тоог судалгаан дээр үндэслэн тогтоож ан амьтны түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл нийлүүлэлтийг Ой модны аж үйлдвэрийн яамны харъяа Анчдын нийгэмлэг зохион байгуулж, гадаад худалдааг Худалдаа бэлтгэлийн яам өөрийн нэгж агентлагаар дамжуулан зохион байгуулдаг байв. Энэ үед ангийн нөөцийг зохистой ашиглах зөв тогтолцоог бүрдүүлж чадснаараа ан амьтны түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны мэдээлэлийн сан сайн бүрдэж байсан.

Төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонд зөвхөн хүнс ахуйн хэрэгцээндээ зориулж ан амьтныг хууль бусаар агнаж байсан бол малын тоо өсөж (манай улс 1991 онд анх удаа 25 сая мал, 2006 онд 34 сая малтай болсон) малчин өрх хүнс, ахуйн хэрэгцээг зэрлэг амьтнаас хангадаг явдал зогссон. Өнөөдөр хууль бус агнуур гарч байгаа шалтгаан нь нэгд

хууль бус бизнес хийж мөнгө олох хоёрт эрх мэдэлтэй хүмүүс амьтдын амиар зугаа цэнгэл хөөцөлдөх явдал болсон.

Ан амьтны түүхий эд, бүтээгдэхүүний үнэ дотоод, гадаадын зах зээлд өсөхийн хэрээр хууль бус агнуур газар авч байна. Зөвхөн 2004 оноос хойш 21 ширхэг цоохор ирвэсний арьс, 90 ширхэг Казакстаны бөхөнгийн эвэр, 114 ширхэг Монгол бөхөнгийн эвэр, 90 ширхэг баавгайн доньд, 100 ширхэг согооний сүүл, 20 ширхэг хүдрийн заарыг хууль бусаар худалдаж авсан болон худалдсанг хууль хяналтын байгууллага илрүүлжээ. Ан **Илрээгүй хэд хичнээн амьтны түүхий эд зарагдсанг хэн ч мэдэхгүй нь хамгийн аймшигтай зүйл юм.**

Дэлхийн байгаль хамгаалах сангийн монгол дахь хөтөлбөрийн газраас 2002 онд хүдрийн заарын хууль бус худалдааны судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд жилд дунджаар 2400-3000 хүдрийн заар хууль бусаар худалдагдаж байсан байна. Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-1 багийн ангийн гаралтай бүтээгдэхүүний судалгааны тайлангаас үзвэл 2002-2004 онд Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн бараан зах дээр 15-20 цоохор ирвэсний арьс, 700 орчим алтайн хойлог хууль бусаар зарагдсан байна. 2001 оноос 2004 он хүртэл Байгаль орчны яамнаас Баян-Өлгий, Ховд, Увс аймагт нийт 61,690 тарвага агнах зөвшөөрлийг хуваарилжээ. Гэтэл дээрх аймгуудын бараан зах дээр тухайн жилүүдэд 587,624 тооны тарваганы арьс буюу зөвшөөрөгдсөн тоон хэмжээнээс 9,5 дахин их арьс хууль бусаар худалдаалагдсан.

2005 онд АНУ-ын төрийн бус байгууллага “Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг” (WCS)-ээс санаачлан Дэлхийн Банкны санхүүжилтээр зохион байгуулсан Ан амьтдын түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны шуурхай үнэлгээгээр манай улс жилд 100 сая орчим долларын ангийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хууль бус худалдаа явагддаг байна. Эдгээрээс үзвэл ан амьтны эд зүйлийн хууль бус худалдаа ямар их хэмжээтэй байгаа нь тодорхой байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь Хөтөлбөрийн газраас боловсруулав.

Дэлгэрэнгүй мэдээллийг nonon@wwf.mn хаягаар авч болно.